

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ногооннуур сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2025/127/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2025 он	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Ахлах аудитор: У.Ербол Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Аймгийн ИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

Ногооннуур сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Төсвийн захирагч

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>71,571,827.50</u>	<u>101,122,647.50</u>
33	АВЛАГА	-	9,046,970.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	9,046,970.00
35	БАРАА МАТЕРИАЛ	71,571,827.50	92,075,677.50
354	Хангамжийн материал	51,471,827.50	71,975,677.50
35420	Аж ахуйн материал	28,969,173.00	49,134,673.00
35440	Түлш, шатах тослох материал	5,837,894.50	6,176,244.50
35470	Бусад хангамжийн материал	16,664,760.00	16,664,760.00
35600	Мал амьтад	20,100,000.00	20,100,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,993,625,557.17</u>	<u>3,940,106,905.09</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,993,625,557.17	3,940,106,905.09
392	Биет хөрөнгө	3,986,670,318.17	3,932,679,147.22
39201	Барилга, байгууламж, орон сууц	804,875,974.00	947,275,974.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(145,246,325.52)	(181,389,331.00)
39203	Авто-гээврийн хэрэгсэл	321,398,435.00	469,572,289.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(189,509,897.30)	(222,893,289.95)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	179,832,143.00	225,750,193.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(86,715,492.62)	(109,933,318.58)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	83,491,736.00	93,049,736.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(48,392,111.16)	(58,234,198.02)
39209	Зам, гүүрийн байгууламж	4,714,423,332.10	4,714,423,332.10
39210	Хуримтлагдсан элэгдэл	(1,649,121,075.33)	(1,946,575,839.33)
39217	Ном	1,633,600.00	1,633,600.00
393	Биет бус хөрөнгө	6,955,239.00	7,427,757.87
39301	Програм хангамж	2,509,639.00	3,279,639.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,086,400.00)	(1,383,881.13)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,532,000.00	5,532,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,065,197,384.67</u>	<u>4,041,229,552.59</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,065,197,384.67</u>	<u>4,041,229,552.59</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,065,197,384.67	4,041,229,552.59
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	833,187,694.44	833,187,694.44
51101	Өмч: - төрийн	833,187,694.44	833,187,694.44
512	Хуримтлагдсан үр дүн	2,360,106,280.09	2,336,138,448.01
51210	Өмнөх үеийн үр дүн	2,455,123,079.18	2,360,106,280.09
51220	Тайлант үеийн үр дүн	(95,016,799.09)	(23,967,832.08)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	871,903,410.14	871,903,410.14

Ногооннуур сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,065,197,384.67	4,041,229,552.59
---	---	------------------	------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,231,482,910.00	1,761,216,818.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	276,650,925.00	374,232,050.00
120	Нийтлэг татварын бус орлого	276,650,925.00	374,232,050.00
120009	Бусад орлого	-	446,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	267,400,925.00	357,286,050.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	9,250,000.00	16,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	954,831,985.00	1,386,984,768.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,696,285.00	12,044,568.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,413,834.00	12,044,568.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,282,451.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	944,135,700.00	1,374,940,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	944,135,700.00	1,374,940,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,326,499,709.09	1,771,839,669.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,326,499,709.09	1,771,839,669.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,318,660,297.09	1,676,156,969.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	530,076,566.83	969,984,630.00
210101	Үндсэн цалин	370,841,813.00	483,538,030.00
210102	Нэмэгдэл	121,014,746.00	395,339,600.00
210104	Урамшуулал	-	21,107,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	38,220,007.83	70,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,780,991.17	113,629,100.00
210201	Тэтгэврийн даатгал	67,780,991.17	74,467,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	9,790,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	4,895,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	4,895,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	19,580,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,211,413.00	22,661,651.00
210301	Гэрэл, цахилгаан	4,934,458.00	5,500,001.00
210302	Түлш, халаалт	11,276,955.00	17,161,650.00
2104	Хангамж, бараа материалын зардал	92,665,791.00	66,936,481.00
210401	Бичиг хэрэг	4,126,000.00	3,871,013.00
210402	Тээвэр, шатахуун	83,371,391.00	58,252,468.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,770,900.00	4,632,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	397,500.00	76,000.00
210408	Бараа материал акталсны зардал	-	105,000.00
2105	Нормативт зардал	2,930,000.00	996,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,930,000.00	996,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,323,740.00	12,711,299.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,998,440.00	1,250,000.00
210604	Урсгал засвар	22,325,300.00	11,461,299.00

Ногооннуур сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал	9,690,000.00	9,700,000.00
210702	Дотоод албан томилолт	9,690,000.00	9,700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,095,060.00	26,016,387.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,511,600.00	23,943,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	521,987.00
210803	Даатгалын үйлчилгээ	92,400.00	184,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	399,200.00	392,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	85,000.00	120,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	838,000.00	681,000.00
210807	Газрын төлбөр	123,760.00	128,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	45,100.00	44,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	541,886,735.09	453,520,621.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	99,712,435.00	48,940,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,733,000.00	550,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	440,441,300.09	404,029,721.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,839,412.00	95,682,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	95,682,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	33,947,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	60,684,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,051,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7,839,412.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,839,412.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(95,016,799.09)	(10,622,851.09)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	13,344,980.99
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө	-	13,344,980.99
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(13,344,980.99)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(95,016,799.09)	(23,967,832.08)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	954,831,985.00	1,387,430,768.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	446,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	446,000.00
120009	Бусад орлого		446,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	954,831,985.00	1,386,984,768.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,696,285.00	12,044,568.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,413,834.00	12,044,568.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,282,451.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	944,135,700.00	1,374,940,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	944,135,700.00	1,374,940,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	905,331,985.00	1,380,860,768.00

Ногооннуур сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

21	УРСГАЛ ЗАРДАЛ	905,331,985.00	1,380,860,768.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	897,492,573.00	1,285,178,068.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	557,672,506.00	979,031,600.00
210101	Үндсэн цалин	336,841,813.00	492,585,000.00
210102	Нэмэгдэл	121,014,746.00	395,339,600.00
210104	Урамшуулал	4,815,947.00	21,107,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	95,000,000.00	70,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,273,098.00	113,629,100.00
210201	Тэтгэврийн даатгал	35,825,599.00	74,467,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,611,899.00	9,790,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,489,500.00	4,895,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,122,400.00	4,895,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,223,700.00	19,580,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,664,985.00	23,000,000.00
210301	Гэрэл, цахилгаан	7,125,000.00	3,500,000.00
210302	Түлш, халаалт	14,539,985.00	19,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	76,265,149.00	57,296,468.00
210401	Бичиг хэрэг	3,420,000.00	3,242,000.00
210402	Тээвэр, шатахуун	67,747,249.00	48,752,468.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,770,900.00	4,632,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	327,000.00	470,000.00
2105	Нормативт зардал	2,930,000.00	700,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,930,000.00	700,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,169,440.00	12,886,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,998,440.00	1,243,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	71,000.00	143,200.00
210604	Урсгал засвар	33,100,000.00	11,500,000.00
2107	Томилот, зочны зардал	9,690,000.00	9,700,000.00
210702	Дотоод албан томилот	9,690,000.00	9,700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,059,860.00	26,007,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,395,900.00	23,943,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,500.00	513,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	92,400.00	184,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	399,200.00	392,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	85,000.00	120,400.00

Ногооннуур сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	838,000.00	681,000.00
210807	Газрын төлбөр	123,760.00	128,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	45,100.00	44,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	100,767,535.00	62,926,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	98,628,535.00	61,864,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,139,000.00	1,062,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,839,412.00	95,682,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	95,682,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		33,947,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		60,684,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,051,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7,839,412.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,839,412.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	49,500,000.00	6,570,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	49,500,000.00	6,570,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	49,500,000.00	6,570,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	49,500,000.00	6,570,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	49,500,000.00	6,570,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(49,500,000.00)	(6,570,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	832,907,694.44	884,987,310.14	2,455,123,079.18		4,173,018,083.76
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	832,907,694.44	884,987,310.14	2,455,123,079.18	0.00	4,173,018,083.76
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	280,000.00				280,000.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт		(13,083,900.00)			-13,083,900.00
C07	Тайлант үеийн үр дүн			(95,016,799.09)		-95,016,799.09
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	833,187,694.44	871,903,410.14	2,360,106,280.09	0.00	4,065,197,384.67
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	833,187,694.44	871,903,410.14	2,360,106,280.09	0.00	4,065,197,384.67
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	833,187,694.44	871,903,410.14	2,360,106,280.09	0.00	4,065,197,384.67
D08	Тайлант үеийн үр дүн			-23,967,832.08	0.00	-23,967,832.08
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	833,187,694.44	871,903,410.14	2,336,138,448.01	0.00	4,041,229,552.59

Ногооннуур сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр/

БӨА-2025/127/НА-СТА-ТШЗ

Ногооннуур сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Хэтрэлт, хэмнэлт	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,423,958,200.00	1,374,940,200.00	49,018,000.00	96.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,423,958,200.00	1,374,940,200.00	49,018,000.00	96.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,328,275,500.00	1,279,257,500.00	49,018,000.00	96.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	979,031,600.00	979,031,600.00	-	100.0
210101	Үндсэн цалин	492,585,000.00	492,585,000.00	-	100.0
210102	Нэмэгдэл	395,339,600.00	395,339,600.00	-	100.0
210104	Урамшуулал	21,107,000.00	21,107,000.00	-	100.0
210105	Гэрээт ажлын хөлс	70,000,000.00	70,000,000.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимт	113,629,100.00	113,629,100.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	74,467,800.00	74,467,800.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	9,790,300.00	9,790,300.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,895,200.00	4,895,200.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	4,895,200.00	4,895,200.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	19,580,600.00	19,580,600.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,000,000.00	23,000,000.00	-	100.0
210301	Гэрэл, пахилгаан	3,500,000.00	3,500,000.00	-	100.0
210302	Түлш, халаалт	19,500,000.00	19,500,000.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	53,784,800.00	53,784,800.00	-	100.0
210401	Бичиг хэрэг	3,242,000.00	3,242,000.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	45,240,800.00	45,240,800.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интэрнэтийн төлбөр	4,632,000.00	4,632,000.00	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал	200,000.00	200,000.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	470,000.00	470,000.00	-	100.0
2105	Нормативт зардал	700,000.00	700,000.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	700,000.00	700,000.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,886,600.00	12,886,600.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,243,400.00	1,243,400.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	143,200.00	143,200.00	-	100.0
210604	Урсгал засвар	11,500,000.00	11,500,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	9,700,000.00	9,700,000.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	9,700,000.00	9,700,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	78,525,400.00	29,507,400.00	49,018,000.00	37.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчлэл	76,161,500.00	27,143,500.00	49,018,000.00	35.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	513,000.00	513,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	184,800.00	184,800.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	392,000.00	392,000.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,400.00	120,400.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	981,000.00	981,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	128,400.00	128,400.00	-	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	44,300.00	44,300.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,018,000.00	57,018,000.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,956,000.00	55,956,000.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,062,000.00	1,062,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	95,682,700.00	95,682,700.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	95,682,700.00	95,682,700.00	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэвэр	33,947,700.00	33,947,700.00	-	100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	60,684,000.00	60,684,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,051,000.00	1,051,000.00	-	100.0
13	ЗАРДЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,423,958,200.00	1,374,940,200.00	49,018,000.00	96.6
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,423,958,200.00	1,374,940,200.00	49,018,000.00	96.6
132001	Орон нутгийн төсвөөс	1,423,958,200.00	1,374,940,200.00	49,018,000.00	96.6
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	
610001	Төсвийн байгууллага	1	1	-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	32	42	(10)	
620001	Удирдах ажилтан	13	13	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	12	12	-	
620003	Үйлчлэх ажилтан	2	2	-	
620004	Гэрээт ажилтан	5	15	(10)	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	32	42	(10)	
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	9	-	
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТУ)	5	5	-	
650010	Гэрээт ажилтан	5	15	(10)	
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	13	13	-	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,490,568.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,490,568.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,490,568.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,511,668.00
210402	Тээвэр, шатахуун	3,511,668.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,978,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,978,900.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,490,568.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,490,568.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,044,568.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	446,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:

Ногооннуур сумын Засаг даргын тамгын газар нь Төрийн албаны болон холбогдох хууль тогтоомжуудыг мөрдлөг болгож, авлига, ашиг сонирхлын зөрчилд автахгүй, үйл ажиллагаандаа төрийн албаны стандартыг мөрдөн, ажлын цагийн ашиглалтыг сайжруулж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний ажлын хөнгөн шуурхай байдлыг хангах, байгууллагын санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд ил тод байдлыг хангаж ажиллана гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Ногооннуур сумын Засаг даргын Тамгын газрын чиг үүрэг нь Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төрийн албаны тухай хууль болон бусад эрх зүйн актуудыг удирдлага болон хэтийн төлөвлөгөөний биелэлт, байгууллага, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг тасралтгүй хангаж ажиллах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллахад оршино.

Ногооннуур сумын Засаг даргын тамгын газар нь эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Ногооннуур сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон олон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон олон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, БӨА-2025/127/НА-СТА-ТШЗ

Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэв.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ногооннуур сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Сумын Засаг даргын тамгын газрын даргын 2023 оны А/02 тоот тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ногооннуур сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны А/229 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 429.5 сая төгрөгөөр буюу 5.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	0	9,047.0	9,047.0

Ногооннуур сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Урьдчилгаа			
Бараа материал	71,571.8	92,075.7	20,503.9
Үндсэн хөрөнгө	3,993,625.6	3,940,106.9	(53,518.7)
Нийт хөрөнгө	4,065,197.5	4,041,229.6	(23,967.8)
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,065,197.5	4,041,229.6	(23,967.8)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,065,197.5	4,041,229.6	(23,967.8)

Дансны авлага 9.0 сая төгрөгөөр өссөн нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлага байна.

Бараа материалын данс 20.5 сая төгрөгөөр өссөн нь аж ахуйн материалын худалдан аюаль болон нүүрсний үлдэгдэлтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 53.5 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 6.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, аймгийн ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжсэн 19.4 сая төгрөгийн гэрэлтүүлэг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 56.5 сая төгрөгийн гэрэлтүүлэг, 35.2 сая төгрөгийн 13 мотоцикл, 18.0 сая төгрөгийн под станц, 8.0 сая төгрөгийн тоглоомын талбай, 30.0 сая төгрөгийн барилгын их засвар, 20.0 сая төгрөгийн сүлжээний 4G төхөөрөмж Засгийн газраас шийдвэрээр нийлүүлсэн 130.0 сая төгрөгийн “Ford Raptor” маркийн авто машин, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 12.8 сая төгрөгийн компьютерээр нэмэгдэж, балансаас баланст шилжүүлсэн 17.0 сая төгрөгийн авто машин болон элэгдлийн зардал өссөнтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант оны үр дүнгээр 23.9 сая төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,169.9 сая төгрөг, нийт зарлагыг 1,169.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 163.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, Ногооннуур сумын ИТХ-ын хуралдааны 78 дугаар тогтоолоор 1,333.7 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Ногооннуур сумын ИТХ-ын хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/02 тогтоолоор төсвөт тодотгол хийгдэж нийт дүнгээр 90.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,423.9 төгрөгөөр баталсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,423.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,374.9 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаагаа явуулсан ба сумын орон нутгийн төсвийн орлого тасарснаас 49.0 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

Батлагдсан орон тоо Тамгын газарт 21, багийн Засаг дарга 11, нийт 32 боловч, гүйцэтгэлээр 42 албан хаагч ажиллаж, орон тооноос 10 орон тоо илүү ажиллуулсан.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,374.9 сая төгрөг буюу 96.6 хувьтай байгаа нь санхүүжилтийг дутуу олгосонтой холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл
БӨА-2025/127/НА-СТА-ТШЗ

Ногооннуур сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
70106	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	1,423,958.2	1,374,940.2	49,018.0	92.0%
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	826,303.8	826,303.8		100%
80102	Туслах үйл ажиллагааны зардал	370,877.7	370,877.7		100%
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	95,682.7	95,682.7		100%
81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	55,956.0	55,956.0		100.0%
81701	Байгаль орчныг хамгаалах	75,138.0	26,120.0	49,018.0	34.7%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн санхүү-нийцлийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгаануудын дүн дараах байдалтай байна. Үүнд:

- Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу сан байгуулаагүй, ахмадын сангийн харилцах данс нээлгээгүй байна.
- Худалдан авах ажиллагааг төлөвлөж ажиллаагүй, нийт 8,805.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, эд хогшлыг худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан авалт хийгдээгүй зөрчилд албан шаардлага өгч ажиллав.
- Байгууллагын 2024 оны орон тооны судалгааг гаргуулж авч, хянаж үзэхэд батлагдсан орон тооны хязгаарыг 8 орон тоогоор хэтрүүлж, төсвөөс 79,200.0 мянган төгрөг зарцуулсан зөрчилд зөвлөмж өгөв.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Засаг даргаас 6.0 сая төгрөгийн, Статистикийн хэлтсээс 6.0 сая төгрөг, малчдын картын хураамжаас 0.5 сая төгрөгийн орлогын эх үүсвэрээр санхүүжилтээр авч аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс нээсэн эрхийн дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Ногооннуур сумын Засаг даргын Тамгын газар 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Ногооннуур сумын Засаг даргын Тамгын газар нь 2024 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж ажиллаагүй байна. Батлагдсан төсвийн хүрээнд 101.6 сая төгрөгийн бараа материал, 6.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу аймгийн Ногооннуур сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 3/19 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Ногооннуур сумын Засаг даргын Тамгын газрын төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1.5 хувиар тогтоосон суурь үзүүлэлтээр тооцож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 14,923.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж тайлант оны нийт зардлын дүн их хэмжээгээр өөрчлөгдсөн тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 75 хувиар буюу 19,933.2 мянган төгрөгөөр тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад худалдан авах ажиллагааг төлөвлөж ажиллаагүй, 8.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, эд хогшлыг цахим дэлгүүрээс бусад газраас худалдан авсан.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх БӨА-2025/127/НА-СТА-ТШЗ

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнээс 1,380.9 сая төгрөгийн 51 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээнээс 130.6 сая төгрөгийн 16 мэдээллийг оруулахаас, мэдээлбэл зохих бүх мэдээллийг цаг тухайд нь бүрэн мэдээлж ажилласан байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Ногооннуур сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 49.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 11.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдсөн ба бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	49,500.0	1	49,500.0	100%
Зөвлөмж	1	11,982.0	1	11,982.0	100%
Нийт дүн	2	61,482.08	2	61,482.0	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан цалингийн зардал, хөрөнгийн тооллогыг түүвэрлэн шалгасан тул гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **62,362.9** мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад **62,362.9** мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

Санхүүгийн үр дүнгийн тайланд балансаас баланст шилжсэн 13,344.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг зардлаар бүртгэсэнийг залруугав.

Төсвийн гүйцэтгэлийн тайланд бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн төлөвлөгөөг 49,018.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг залруулав.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-ийн 4.1.3, 5 дугаар зүйл 5.1-ийн 5.1.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Сангийн сайдын 2023 оны А/229 тоот тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" болон УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт **120,358.4** мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, **31,258.4** мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, **89,100.0** мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

Байхгүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар **31,258.4** мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

1.Тээвэр шатахууны зардлаас нийт 19,523.4 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан боловч жолоочийн замын тооцооны хуудас дутуу хөтөлсөн, шатахууны хэтрэлт, хэмнэлтийн тооцоо бодоогүй, шатахуун олгох талонд нягтлан бодогчийн гарын үсэггүй, зөвхөн даргын цохолтоор зарцуулсан, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 41 дүгээр зүйлийн 41.2-ийн 41.2.3, Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.1.3, Сангийн сайдын 2023 оны А/229 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам", 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан "Жишиг норм батлах тухай" журмын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.
БӨА-2025/127/НА-СТА-ТШЗ

Ногооннуур сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.Тайлант онд худалдан авах ажиллагааг төлөвлөж ажиллаагүй, 8,805.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, эд хогшлыг худалдан авахдаа цахим худалдан авалтын журмыг зөрчсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, 37 дугаар зүйлийн 37.1.2, 38 дугаар зүйлийн 38.1 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

3. Сумын Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн “Балансын урамшуулал олгох тухай” А/128 дугаар захирамжийг үндэслэн санхүүгийн албаны дарга, нягтлан бодогч нарт 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан гэж 2,930.0 мянган төгрөгийн урамшуулал олгож, төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын хэмжээг хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5-ийн 16.5.5, Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бүтэц, орон тоотой холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Ногооннуур сумын Тамгын газрын ажиллагсдын үндсэн ажилтны орон тоо 21, багийн Засаг дарга нарын орон тоо 11, нийт 32 орон тоогоор үйл ажиллагаагаа явуулах ёстой байсан боловч орон нутгийн орлогын давсан хэсгээс санхүүжүүлж 10 гэрээт ажилтан нэмж ажиллуулж, нийт 89,100.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.9-т “дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох”, 66 дугаар зүйлийн 66.1-т “Сум, дүүргийн Засаг дарга, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагч орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 66.1.7-т “тухайн шатны төсвийн байгууллагын орон тоог төсвийн захирагч бүрээр батлах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.2-т “чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох”, Засгийн газрын 2009 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Сумын засаг даргын тамгын газрын орон тооны хязгаарыг тогтоох тухай” журмын 1-д “Хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, үйлчлэх өрх, аж ахуйн нэгж, байгууллагын тоог харгалзан сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг..... 5001-10000 хүртэл хүн амтай суманд 18,

Ногооннуур сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

10001-20000 хүртэл хүн амтай суманд 21, 20001-ээс дээш хүн амтай суманд 23 байхаар тус тус тогтоосугай” гэсэн заалтуудад нийцэхгүй байна.

1.1 Өгсөн зөвлөмж: Батлагдсан орон тооны хязгаарт багтаан орон тоог үндэслэлтэй тогтоох, орон тооны нягтралыг сайжруулах замаар төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах.

Аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
СҮДТ-д балансаас баланст шилжсэн үндсэн хөрөнгийг зардлаар бүртгэсэн	1	13,344.9			1	13,344.9	1	13,344.9				
ТГТ-д БГБНАҮТХ-ийн зардлын төлөвлөгөөг дутуу тайлагнасныг залруулав.	1	49,018.0			1	49,018.0	1	49,018.0				
Дүн	2	62,362.9			2	62,362.9	2	62,362.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хууль тогтоомж зөрчин балансын	1	2,930.0			1	2,930.0						

Ногооннуур сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

шагнал олгосон												
Шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй	1	19,523.4			1	19,523.4						
Илүү орон тоогоор ажилласан	1	89.100.0					1	89.100.0				
Дүн	3	111,553.4			2	22,453.4	1	89,100.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Цахим худалдан авалтыг хууль зөрчсөн	1	8,805.0			1	8,805.0		
Нийт дүн	1	8,805.0			1	8,805.0		